

АЙМГУУДЫН ХҮНС, ХӨДӨӨ, АЖ АХУЙН ГАЗРЫН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2017.01.12

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

1.1. Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газраас хэрэгжүүлсэн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хүрсэнтүвшинг тогтоон удирдлагыг бодит мэдээлэл, санал-дүгнэлт, зөвлөмжөөр хангах, мөн түүнчлэн байгууллагын гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах зорилготой.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилт

2.1. Хүнс, хөдөө аж ахуйнсалбарын бодлогын зорилт нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцно.

2.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, дүгнэлтийг үндэслэн салбарын байгууллагууд үйл ажиллагааны зорилтоо тодорхойлох төлөвлөгөө, бодлогын хувилбар, санал боловсруулахад дэмжлэг үзүүлэх, агентлагийн дарга, Засаг дарга болон холбогдох байгууллагын удирдлагад шийдвэр гаргахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.

2.3. Хүнс, хөдөө аж ахуйнсалбарын байгууллагын стратеги зорилт, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төлөвлөлт, гүйцэтгэл, дунд болон урт хугацааны үр дүн, үр нөлөөг сайжруулна.

2.4. Байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн санг бүрдүүлж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангана.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

3.1 Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам” болон Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны А/85 дугаар тушаалаар батлагдсан “Салбарын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ыг удирдлага болгов.

3.2 Ерөнхий үнэлгээний дүнг гаргахдаа бүрэлдэхүүн хэсгүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлэн, нийт дүнд (100) эзлэх итгэлцүүр тогтоосон бөгөөд энэ нь бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнд 20 хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтэд 20 хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээнд 10 хувь, үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээнд 50 хувь байхаар тус тус тооцов. Бүрэлдэхүүн тус бүрийн үнэлгээг гаргахдаа /дэд хэсгийн/ биелэлтийн дундаж хувиар тооцсон болно.

3.3 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ аймгуудын үйл ажиллагааны болон хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг судлах, 2015, 2016 оны статистик дүн, яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрууд болон харьяа байгууллагуудад аймгуудаас ирүүлсэн мэдээ, мэдээлэлтэй харьцуулалт хийх болон хариуцсан мэргэжилтнээс тодруулга авч нягтлах зэрэг үндсэн аргуудыг ашиглав.

Мөн тайлангийн чанар, агуулга, мэдээллийн үнэн бодит байдал, заасан хугацааг баримталсан эсэхийг үнэлгээний дүнд харгалзан үзсэн болно.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2016 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ 4 бүрэлдэхүүн хэсэг, 12 дэд хэсгийг хамарсан бөгөөд ерөнхий үнэлгээ дунджаар 83.2 хувьтай гарч байна /Нэгдүгээр хүснэгт/.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО

Хүснэгт-1

Үзүүлэлт		Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хувь
Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	82.2
	Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн ЗД, ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт; /ХХАА-н салбарт хэрэгжиж буй 5 дэд хөтөлбөр/	85.8
	Аймгийн эдийн засаг, нийгмийг тухайн онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт;	80.0
	ДУНДАЖ	82.7
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	Төсвийн ерөнхийлөн захирагчаас ХХААГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт;	84.5
	Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт; /4 салбар/	-
	Сумдын мал эмнэлэг, үржлийн тасгийн тухайн жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээ	78.4
	Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт;	85.7
	ДУНДАЖ	82.8
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын тайлан	83.7
	Хэрэглэгчийн үнэлгээ	70.6
	ДУНДАЖ	77.2
Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	Хүнсний салбар	90.4
	Мал эмнэлгийн салбар	90.7
	Мал аж ахуйн салбар	80.0
	Газар тариалангийн салбар	77.9
	ДУНДАЖ	84.7
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ		83.2

АЙМГУУДЫН ХХААГ-ЫН 2016 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

1/11/2017

№	Аймгууд	Үйл ажиллагааны үр дагаврын				Бодлогын зорилтын					Байгууллагын чиг үүргийн					Байгууллагын нээлттэй				Унэлгээний оноо	Эзэлсэн байр	Суурь түвшин			
		Хүнс	Мал эмнэлэг	Мал аж ахуй	Газар тариалан	Үнэлгээ		Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	Дэд хөтөлбөрүүдийн үнэлгээ	Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх үндсэн чиглэл	Үнэлгээ		Сайд, ХХААГ-ын даргагай байгуулсан гэрээний биелэлт	ХХААГ, сумын МЭҮТ-гай байгуулсан гэрээний биелэлт	Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт	Үнэлгээ		Байгууллагын үйл ажиллагаан ил тод байдлын тайлан	Хэрэглэгчийн үнэлгээ			Үнэлгээ		2015 он	Үнэлгээний зөрүү
						хувь	оноо				хувь	оноо				хувь	оноо					хувь	оноо		
1	Архангай	86.5	90.2	85.0	77.9	84.9	42.5	96.7	93.0	91.5	93.7	18.7	80.1	81.6	83.2	81.6	16.3	80.0	0.0	40.0	4.0	81.52		87.1	-5.54
2	Баян-Өлгий	85.1	96.0	88.6	62.0	82.9	41.5	87.0	84.1	87.5	86.2	17.2	73.5	72.8	81.8	76.0	15.2	88.8	85.3	87.0	8.7	82.61		84.4	-1.78
3	Баянхонгор	81.0	80.9	89.5	69.5	80.2	40.1	50.0	50.0	50.0	50.0	10.0	86.5	74.7	82.2	81.1	16.2	83.3	50.0	66.7	6.7	72.99		86.4	-13.38
4	Булган	91.4	91.2	71.2	82.4	84.1	42.0	87.4	99.0	75.0	87.1	17.4	85.1	83.0	87.0	85.0	17.0	85.0	91.0	88.0	8.8	85.26		86.4	-1.12
5	Говь-Алтай	99.6	92.0	62.9	71.7	81.6	40.8	76.2	65.5	77.4	73.0	14.6	83.3	88.9	82.1	84.8	17.0	83.3	70.0	76.7	7.7	80.01		85.7	-5.66
6	Дорноговь	93.8	93.1	88.5	77.2	88.1	44.1	90.0	88.8	96.1	91.6	18.3	83.5	92.1	90.3	88.6	17.7	76.7	79.0	77.8	7.8	87.75		88.0	-0.25
7	Дорнод	81.6	87.7	77.8	72.8	79.9	40.0	90.0	90.0	90.0	90.0	18.0	82.9	76.3	87.2	82.1	16.4	81.3	90.0	85.6	8.6	82.96		88.4	-5.46
8	Дундговь	90.4	87.9	84.2	71.1	83.4	41.7	97.1	91.8	81.4	90.1	18.0	80.5	79.4	85.4	81.8	16.4	85.0	70.0	77.5	7.8	83.83		85.3	-1.51
9	Завхан	98.3	96.3	82.0	79.3	89.0	44.5	83.5	83.3	74.7	80.5	16.1	82.2	75.0	83.3	80.2	16.0	85.0	83.0	84.0	8.4	85.03		85.3	-0.25
10	Өвөрхангай	87.6	97.1	64.7	90.7	85.0	42.5	92.3	89.3	92.0	91.2	18.2	91.4	89.1	94.1	91.5	18.3	92.3	82.2	87.3	8.7	87.79	III	87.5	0.32
11	Өмнөговь	93.6	91.2	82.4	73.7	85.2	42.6	90.7	73.2	91.3	85.1	17.0	83.4	81.0	82.3	82.2	16.4	86.3	82.6	84.4	8.4	84.51		87.5	-2.98
12	Сүхбаатар	89.0	92.5	75.3	73.9	82.6	41.3	90.0	90.0	80.1	86.7	17.3	82.0	60.0	89.3	77.1	15.4	83.3	77.3	80.3	8.0	82.12		84.9	-2.78
13	Сэлэнгэ	90.8	93.7	83.2	89.4	89.3	44.6	99.2	89.2	87.6	92.0	18.4	92.2	60.0	90.0	80.7	16.1	91.3	83.5	87.4	8.7	87.91	II	89.5	-1.61
14	Төв	85.7	91.1	76.9	81.2	83.7	41.9	89.8	89.8	80.6	86.7	17.3	85.3	82.0	84.5	84.0	16.8	90.0	75.4	82.7	8.3	87.93	I	88.0	-0.07
15	Увс	85.3	82.9	79.3	77.3	81.2	40.6	87.1	85.7	71.1	81.3	16.3	84.3	84.5	85.5	84.8	17.0	70.0	74.8	72.4	7.2	81.06		85.1	-4.09
16	Ховд	95.4	93.9	81.4	72.1	85.7	42.9	80.2	90.0	75.0	81.7	16.3	79.4	60.0	85.0	74.8	15.0	80.0	91.6	85.8	8.6	82.74		86.7	-4.00
17	Хөвсгөл	95.8	94.8	87.8	88.7	91.8	45.9	65.8	84.9	87.5	79.4	15.9	88.4	86.0	82.6	85.7	17.1	91.3	50.0	70.6	7.1	85.97		84.5	1.51
18	Хэнтий	92.0	89.1	66.6	79.2	81.7	40.9	10.0	94.0	43.3	49.1	9.8	84.0	83.9	84.5	84.1	16.8	80.0	30.0	55.0	5.5	73.01		88.5	-15.49
19	Дархан-Уул	85.6	87.4	77.9	84.5	83.9	41.9	91.6	90.9	72.8	85.1	17.0	90.0	81.0	85.9	85.6	17.1	92.5	82.4	87.5	8.7	84.82		88.1	-3.26
20	Орхон	97.4	80.2	83.3	85.9	86.7	43.4	89.2	89.2	93.2	90.5	18.1	95.2	91.3	87.4	91.3	18.3	88.8	52.7	70.7	7.1	86.64		88.1	-1.49
21	Говьсүмбэр	90.0	96.2	74.8	71.4	83.1	41.6	82.4	90.0	81.7	84.7	16.9	80.3	63.0	85.3	76.2	15.2	72.5	63.0	67.8	6.8	80.52		84.9	-4.39
	Дүн	90.3	90.7	79.2	77.7	84.5	42.2	82.2	85.8	80.0	82.7	16.5	84.5	78.4	85.7	82.8	16.6	84.1	69.7	76.9	7.7	83.19		86.7	-3.49

4.1. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ

Уг бүрэлдэхүүн хэсэг нь Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн ЗД, ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт, Аймгийн эдийн засаг, нийгмийг тухайн онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт гэсэн дэд хэсэгтэй ба эдгээр бодлогын баримт бичигт тусгагдсан салбарт хамаарах арга хэмжээний хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгаас тухайн зорилт, арга хэмжээг үнэлсэн дүнгээр авав. “Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ” бүрэлдэхүүн хэсгийн дундаж үнэлгээ **82.7** хувьтай байна.


График-1



4.1.1. Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт


Хүнс, хөдөө аж ахуйн газрууд Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамаарах арга хэмжээг хяналтад авч хэрэгжүүлж байна. Дэд хэсгийн хэрэгжилт 74.8-91.5 хувьтай дүгнэгдсэн ба дундаж үнэлгээ **82.2** хувьтай байна.

График- 2



4.1.2. Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн ЗД, ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж буй “Хүнсний аюулгүй байдал”, “Чацаргана”, “Монгол мал”, “Эрчимжсэн мал аж ахуй” дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт дунджаар **85.8** хувь гэж дүгнэгдсэн /График-2/. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үнэлгээгээр Булган аймаг хамгийн өндөр буюу **99.0** хувь, Говь-Алтай, Баянхонгор аймгууд хамгийн бага хувьтай байна.




4.1.3. Аймгийн эдийн засаг, нийгмийг тухайн онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамаарах 2-90 арга хэмжээ тусгагдсаныг хяналтад авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна. Дэд хэсгийн хэрэгжилт 43.3-96.1 хувьтай дүгнэгдсэн ба дундаж үнэлгээ **80** хувьтай байна. /График -3/ 80 хувиас бага үнэлгээтэй 2 аймаг, 80-90 хувийн үнэлгээтэй 3 аймаг, бусад аймаг 90 хувиас дээш үнэлгээтэй байна.

Аймгуудын үндсэн чиглэлд тусгагдсан ХХАА-н салбарт хамаарах арга хэмжээний тоо хэт өндөр зөрүүтэй байгаа нь төлөвлөлтийг үндэслэлтэй, судалгаанд тулгуурлан бодитой хийх шаардлага байгааг харуулж байна. Үндсэн чиглэл нь богино хугацааны бодлогын баримт бичиг бөгөөд нэг жилийн хугацаанд хэрэгждэг тул хэрэгжих боломжтой, тодорхой үр дүнд хүрэх, санхүүжилт шийдвэрлэгдсэн арга хэмжээнүүдийг оруулах нь зүйтэй.

График -4




4.2. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ

Уг бүрэлдэхүүн хэсэг нь Хүнс, хөдөө аж ахуйн сайдаас ХХААГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, Аймгийн ХХААГ-аас Сумдын мал эмнэлэг, үржлийн тасагтай байгуулсан тухайн жилийн хамтран ажиллах гэрээний биелэлтийн дүн, Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт гэсэн дэд хэсгүүдтэй ба “Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ” бүрэлдэхүүн хэсгийн дундаж үнэлгээ **82.8** хувьтай дүгнэгдлээ.

4.2.1. Хүнс, хөдөө аж ахуйн сайдаас ХХААГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт;

Хүнс, хөдөө аж ахуйн сайдаас ХХААГ-ын даргатай байгуулсан 2016 оны үр дүнгийн гэрээний биелэлтэд аргачлалын дагуу яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрууд үнэлгээ хийж, Төрийн захиргааны удирдлагын газраас дүнг нэгтгэн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлсэн. Үр дүнгийн дундаж үнэлгээ **84.5** хувьтай байна.

График- 5



4.2.2. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

Байгууллагын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг Булган, Дорнод, Орхон, Говьсүмбэр аймгуудаас бусад аймгууд ирүүлээгүй тул уг дэд хэсгийн дүнг ерөнхий үнэлгээнд оруулаагүй болно.

4.2.3. Аймгийн ХХААГ-аас Сумдын мал эмнэлэг, үржлийн тасагтай байгуулсан тухайн жилийн хамтран ажиллах гэрээний биелэлтийн дүн

Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газруудаас сумдын мал эмнэлэг, үржлийн тасагтай байгуулсан 2016 онд хамтран ажиллах гэрээг дүгнэсэн дүн дунджаар **78.4** хувьтай байна. Хамгийн өндөр үнэлгээтэй нь Баянхонгор, Баян-Өлгий аймгууд байна.

График- 6



4.2.4. Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт

Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ байгууллагын үйл ажиллагаанд Үндэсний болон аймгийн аудитын газраас хийсэн санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын зөвлөмж болон удирдах дээд байгууллагаас хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг харгалзан үзлээ.

Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилт дунджаар 85.7 хувьтай үнэлэгдсэн ба Орхон аймаг 92.9, Дорноговь аймаг 92.1, Сэлэнгэ аймаг 90.0, Өмнөговь аймаг 89.5 хувиар тус тус дүгнэгдэж бусад аймгуудаа тэргүүлж байна.


График -7



4.3. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ

Уг бүрэлдэхүүн хэсгийн Хэрэглэгчийн үнэлгээ дэд хэсгийн дүнг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгаас ирүүлсэн үнэлгээгээр авсан ба байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын тайланд яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар үнэлгээ хийв. “Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ” бүрэлдэхүүн хэсгийн дундаж үнэлгээ **77.2** хувьтай байна.

График -8



4.3.1. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын тайлан

Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн биелэлт дунджаар **83.8** хувьтай үнэлэгдсэн. Өвөрхангай, Дархан-Уул, Хөвсгөл аймгуудын ХХААГ-ын цахим хуудасны ашиглалт, мэдээлэл түгээлт хангалттай байна.

ХХААГ-ууд байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарынхаа бүтэц, агуулгыг сайжруулан, цаг үеийн мэдээллээ тогтмол оруулж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хэрэглэгчдэд хүргэх талаар санаачлагатай ажиллан үйл ажиллагааны ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн тайландаа тусгахад анхаарах хэрэгтэй.


График-9



4.3.2. Хэрэглэгчийн үнэлгээ

Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагаанд өгсөн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан иргэдийн дундаж үнэлгээ 69.7 хувьтай байна. Хэрэглэгчийн үнэлгээгээр Ховд аймаг хамгийн өндөр буюу 91.6 хувь, Архангай аймаг хэрэглэгчийн үнэлгээ ирүүлээгүй байна.

График-10



4.4. Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ

Аргачлалд тусгагдсанаар уг бүрэлдэхүүн хэсэг нь хүнс, мал эмнэлэг, мал аж ахуй, газар тариалангийн салбар гэсэн дэд хэсгүүдтэй ба “Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ” бүрэлдэхүүн хэсгийн дундаж үнэлгээ **84.7** хувьтай байна.

4.4.1. Хүнсний салбар

Аймгуудын Хүнс Хөдөө аж ахуйн газрын хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр хийсэн ажлын ерөнхий үнэлгээ дунджаар 90.4 хувьтай дүгнэгдсэн байна.

ХХАА-н сайдын 2015 оны А-85 дугаар тушаалаар баталсан “Салбарын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын хавсралтын Е-д заасан Хүнсний салбарын үр дүнгийн үзүүлэлтийг үнэлэх хүснэгтийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийв. 6 чиглэлээр 32 үзүүлэлтээр үнэлэв.

- Орон нутгаас хүнсний салбарт үзүүлсэн дэмжлэг
- Хүнсний үйлдвэрийн тоо
- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Хангамж, хувь
- Гол нэрийн бүтээгдэхүүний жижиглэнгийн үнэ/жилийн дундаж/
- Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр хийсэн ажил

2016 онд нийт 21 аймгийн ХХААГ-т орон нутгаас “Хүнсний аюулгүй байдал” дэд хөтөлбөрийн санхүүжилтэд нийт 2 тэрбум 25 сая төгрөг зарцуулж, хүнс чиглэлийн үйлдвэрлэл эрхлэгч 655 аж ахуйн нэгж, иргэнд 3 тэрбум 308 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлсэн байна.


Хүнс үйлдвэрлэлийн салбарт 63 цех, 14 үйлдвэр шинээр ашиглалтад оруулж, 787 ажлын байр шинээр бий болгожээ. Цехийн хүчин чадлын ашиглалт 100 харин үйлдвэрийнх 68,5 хувь байна.

График- 11



4.4.2. Мал эмнэлгийн салбар

Мал эмнэлгийн салбарын 2015 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэхдээ “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ”, “Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ”, “Паразит өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээ”, “Ариутгал халдваргүйтгэл”, “Лабораторийн шинжилгээ”, “Мэдээ тайланд өгсөн Мал эмнэлэг, үржлийн газрын үнэлгээ”, “Тайлангийн агуулга, чанарт өгсөн үнэлгээ” зэрэг бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд 13 шалгуур үзүүлэлтийг харгалзан хийлээ. Дэд хэсгийн хэрэгжилтийн үнэлгээ дунджаар **90.7** хувь буюу “хангалттай сайн” дүнтэй үнэлэгдсэн.



4.4.3. Мал аж ахуйн салбар

Мал аж ахуйн салбарын үзүүлэлт гэсэн хүснэгтийн дүнгийн нэгтгэлийг аймаг тус бүрээр гаргав. Мал аж ахуйн салбарын үзүүлэлтэд Хээлтэгч хээлтүүлэгчийн тохирооны тоо, өвөлжилтийн бэлтгэл ажлын биелэлт, малын өсөлт, нэг малаас авах ашиг шим, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үзүүлэлт зэргийг багтаасан мэдээллийг ашигласан.

Мал аж ахуйн салбарын дээрх үзүүлэлтүүдийг суурь түвшин, зорилтот түвшин, хүрсэн түвшин зэргийг харгалзан үнэлж байгаа одоогийн систем нь бодит мэдээллийг бүрэн илэрхийлэх, үнэн зөв үнэлгээ хийхэд хангалттай бус байна. Тухайлбал Орхон аймгийн Мал аж ахуйн салбарын үзүүлэлтэд заасан аймгийн түвшин дэх өвөлжилтийн бэлтгэл ажлын биелэлтийн суурь түвшин 92.8, зорилтот түвшин 80.0, хүрсэн түвшин 93.0 хувь буюу 100 хувь гэж үнэлсэн, мөнтүүнчлэн мал аж ахуйн салбарын бүх үзүүлэлт 100 хувь үнэлгээтэй гарсан байна. Эндээс үзэхэд мал аж ахуйн салбарын суурь түвшин, зорилтот түвшин, хүрсэн түвшин, үнэлгээ гэдэг үзүүлэлтүүд бүгд 100 хувь гэсэн дүнтэй гэсэн мэдээлэл ирүүлсэн нь бодит байдалтай нийцэхгүй байгаа жишээ юм.

Аймгуудаас ирсэн Мал аж ахуйн салбарын үнэлгээ харьцангуй өндөр байна. Аймгуудын ХХААГ-ын Мал аж ахуйн салбарын үнэлгээ /73.49- 99.43/ хувьтай, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан дүнгийн тухай үнэлгээ /64.5-95.6/ хувьтай, Мал эмнэлэг, үржлийн газрын Мал аж ахуйн хэлтсийн ажлыг дүгнэсэн үнэлгээ /4.0-96.0/ хувьтай гарч байна. Эдгээр дүнгүүдийг нэгтгэж дундаж үнэлгээг гаргасан.

Аймгуудын ХХААГ-ын Мал аж ахуйн салбарын дундаж үнэлгээг гаргасан ба 62.90-89.46 хувьтай гарч байна. ХХААГ-ын 2016 оны мал аж ахуйн чиглэлийн үйл ажиллагааг үндсэн 6 шалгуур үзүүлэлтээр, ХХААЯ-ны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газар болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газрын мал аж ахуйн хэлтэс, аймгуудын ХХААГ-ын тайлан мэдээлэлд тулгуурлан үнэлэв.

Үнэлгээний дүнгээр Төв аймаг 92.9, Баянхонгор 89.5, Дорноговь 88.5, Хөвсгөл 87.7, Архангай 85.0 хувиар хангалттай гэж дүгнэгдэв.



4.4.4. Газар тариалангийн салбар

Газар тариалангийн салбарыг үнэлэхдээ “Газар тариалангийн үйлдвэрлэл”, “Газар тариалангийн салбарын бүтээмж”, “Усалгаатай тариалан”, “Хамгаалагдсан хөрс”, “Зоорины хангамж”, “Сургалт”, “Тариалангийн газрын ашиглалт, зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажлын үнэлгээ”, “Тайлангийн чанар” гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг шалгуур болгон хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ. Аймгуудын ХХААГ-ын 2015 оны газар тариалангийн салбарын ерөнхий дундаж **77.9** хувьтай үнэлэгдсэн байна.

График -14



Газар тариалангийн үйлдвэрлэлийн хүрээнд 2016 оны ургац хураалтын дүнгээр Улсын хэмжээнд нийт 475.8 мянган тонн үр тариа, үүнээс 460.7 мянган тонн буудай, 153.7 мянган тонн төмс, 93.5 мянган тонн хүнсний ногоо, 22.4 мянган тонн тосны ургамал, 50.3 мянган тонн тэжээлийн ургамал тус тус хураан авсан байна. “Газар тариалангийн үйлдвэрлэл”-ийн үзүүлэлтийн дундаж үнэлгээ 78.0 хувьтай дүгнэгдсэн ба хамгийн өндөр үнэлэгдсэн нь Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл, Орхон, Дархан-Уул аймгууд байна.

Газар тариалангийн бүтээмж дэд хэсгийн үнэлгээ дунджаар **86.3** хувьтай байна. Бүтээмжийг үнэлэхэд улсын хэмжээний үйлдвэрлэлд эзлэх хувь, нэгж талбайн ургацын хэмжээг зорилтот түвшинтэй харьцуулснаас гадна суурь онтой харьцуулж дүгнэв. Булган, Өмнөговь, Сэлэнгэ, Өвөрхангай, Дархан-Уул, Орхон аймгуудын бүтээмж хангалттай сайн үнэлэгдсэн.

Усалгаатай тариалангийн тухайд Усалгаатай тариалангийн үнэлгээ дунджаар **82.6** хувиар дүгнэгдсэн. Аймгуудын хамгаалагдсан хөрсний тариалангийн үнэлгээ дунджаар **91.8** хувьтай байна. Хүлэмжийн аж ахуйгаас хураан авсан ургацын хэмжээг зорилтот түвшинтэй харьцуулахад ихэнхи аймгууд хангалттай сайн үнэлгээ авсан.

Зоорины хангамжийг үнэлэхдээ тухайн аймгийн нийт хураан авсан төмс, хүнсний ногооны ургацын 70 хувийг хадгалах шаардлагатай хэмээн тооцон түүнийг зоорины нийт багтаамжтай харьцуулахад Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Өмнөговь аймгууд 100 хувь хангаж байна.

Газар тариалан эрхлэгчдэд зориулж аймгууд давхардсан тоогоор 487 удаагийн сургалт, семинар зохион байгуулж, тэдгээрт 14815 хүн хамрагдсан байна.

“Тайлангийн чанар”-ын дундаж **80.2** хувьтай дүгнэгдсэн. Газар тариалангийн салбарын үр дүнгийн үзүүлэлтийн мэдээллийг хугацаандаа бүрэн ирүүлэх талаар ахиц гарсан хэдий ч тоон мэдээллүүдийг тооцох аргачлалын зөрүүтэй байдал, мөн яамны дүн мэдээлэлтэй зөрөх гэх зэрэг дутагдлууд байгааг анхаарах шаардлагатай.

ДҮГНЭЛТ

1. Аймгуудын хүнс, хөдөө аж ахуйн газрын 2016 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний ерөнхий дундаж **83.2** хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 3.68 пунктээр буурчээ. Дээрх ерөнхий үнэлгээнд бодлогын зорилтын хэрэгжилтийн үнэлгээ болон байгууллагын нээлттэй байдлын үнэлгээний дүн эрс буурсан нь нөлөөлжээ. Тухайлбал Хэнтий, Баянхонгор аймгийн ЗДТГ-аас ХХААГ-ын үнэлгээний дүнг эрс бууруулсан, үнэлгээ ирүүлээгүй, харин Архангай аймгаас Хэрэглэгчийн үнэлгээний тайлан ирүүлээгүй гэх мэт. Иймд Аймгуудын ХХААГ нь нутгийн болон төрийн захиргааны байгууллагатайгаа хамтын ажиллагаагаа сайжруулах зайлшгүй шаардлагатай байгааг анхааруулж байна.
2. ХХААХҮ-ийн салбаруудын одоогийн суурь түвшинг судалгаа тооцооны үндсэн дээр бодитой тогтоож, суурь түвшнээс хамаарсан төлөвлөлтийг үндэслэлтэй хийж, хүрэх түвшинг тодорхой тогтоож, үр дүнг зөв тайлагнаж, тоонд биш чанарт анхаарч ажиллах шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

1. ХХААХҮ-ийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 01/1497 тоот удирдамжаар хүргүүлсэн зөвлөмжид дурдсаны дагуу ... аймаг, орон нутаг дахь “Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн ... нарыг үндсэн чиг үүргийн дагуу төрийн захиргааны албан хаагчийн ангилалд хамааруулан тогтвор суурьшилтай ажиллуулахыг зөвлөмжөөр хүргүүлж байна.

САНАЛ

1. Аймгийн ХХААГ-ыг үнэлэх ажилд шаардлагатай мэдээлэл, малын төрөл зүйл, газар тариалан, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, ЖДҮ, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, ашиг шим, гарц зэргийг бодитой үнэлэхийн тулд орон нутгийн болон салбарын онцлогийг харгалзсан шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн боловсруулахад аймаг, орон нутгийн мэргэжилтэн, удирдах ажилтан нараас бодитой санал, санаачлага ирүүлэх шаардлагатай байна.